

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨРИЙН  
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 11 дүгээр  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу намууд дүрмээ Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэн баталж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан хугацааг өөрчилж, улс төрийн намуудад дүрмээ шинэчлэх, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтаа боловсронгуй болгох бодит хугацааг тогтоож, хуулийн хэрэгжилтийг нэг мөр, үр дүнтэйгээр зохион байгуулах шаардлагатай гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар улс төрийн намууд дүрмээ хуульд нийцүүлэн шинэчилж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан хугацааг хойшлуулах бодит хэрэгцээ, шаардлага, намуудын байр суурь ямар байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар намын дүрмийг хуульд нийцүүлэн өөрчилж, Улсын дээд шүүхэд хүргүүлэх хугацааг өөрчлөх талаар намуудын гаргасан шаардлага, түүний агуулгын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтувшин хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагуудыг хангасан эсэх, хуульд заасан хугацааг хойшлуулснаар намууд дүрмээ өөрчилж бүртгүүлэх нөхцөл бүрдэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа одоогийн байдлаар хэдэн нам дүрмээ өөрчилж Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн талаар, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу хуулийн төслийг боловсруулсан эсэх, энэ өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хуульд заасан намын санхүүжилтийн талаарх зохицуулалтуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 41.10-т заасан зохицуулалттай нийцэж байгаа эсэх, хуулийн зарим зохицуулалтыг хойшлуулах бодит хэрэгцээ шаардлага бий эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хэлэлцүүлгийн шатанд хуулийн төсөлд заасан хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүртгүүлэхээр өөрчлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Л.Мөнхбаатар нар нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлж шинэчлэн батлахад тодорхой хугацаа шаадлагатай байгаа тул

хугацааг эргэн харах нь зүйтэй талаар, чуулганаар хэлэлцэх эсэхийг дэмжсэн тохиолдолд хуулийн төсөлд заасан хугацааг урагшлуулах боломжийг судлан үзэж, хэлэлцүүлгийн үед өөрчлөх боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтэд анхаарч, хугацаа алдахгүйгээр хуулийг хэрэгжүүлж улс төрийн намын шинэтгэлийг хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг хуульд нийцүүлж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэх асуудлыг хуулийн төсөлд заасан хугацаанаас урагшлуулж, боломжит хугацаагаар тогтоох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, О.Цогтгэрэл Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр заасан хугацааг хойшлуулахыг дэмжихгүй байгаа талаар саналаа илэрхийлсэн болно.

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 83.3 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

